МОНГОЛЫН БАНК БУС
САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

# 2021 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ





МББСБХолбооны эрхэм гишүүд, бидэнтэй хамтран ажилладаг байгууллагууд та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

2021 онд банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 35.0 хувиар, зээлийн хэмжээ өмнөх оноос 52 хувиар өссөн үзүүлэлттэй байж санхүүгийн салбарт тогтвортой өсөлтөөр амжилтаа ахиулсан жил байв. Санхүүгийн технологид суурилсан хөгжил нь ард иргэд, бичил бизнесийн санхүүгийн хүртээмжийг улам нэмэгдүүлж, нийт ББСБ н зээлдэгчийн 80 хувь нь хол ойроос үл хамаарч зөвхөн гар утсаа ашиглаж хэрэгцээтэй санхүүжилтээ авдаг болсон байна.

МББСБХ гишүүдийнхээ хамт нийтлэг эрх ашиг болон нийгмийн хариуцлагын хүрээнд үндсэн ажлуудаа амжилттай хэрэгжүүллээ.

Бид салбарынхаа комплаенс, нийгмийн хариуцлага, засаглалыг улам сайжруулхад онцгой анхаарч, нийт 1000 аад ажилчидыг гадаад дотоодын цахим болон танхимын сургалтуудад хамруулж мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Бид Зээлийн батлан даалтын сан, ТоС холбоо, МҮХАҮТ, МАОЭХ, УБХотын Танхим, FEH, MMF гэх мэт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго нэг бүхий байгууллагуудтай хамтран шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг гишүүн байгууллагууд болон харилцагч нартаа хүргэн ажиллаж байна. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран гишүүн байгууллагуудын бүтээдэхүүн үйлчилгээний хүртээмжийг ард иргэдэд таниулах ажлуудыг амжилттай гүйцэтгэж байна.

Холбоо Санхүүгийн зохицуулах хороотой байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлж холбогдох дүрэм журам, хууль тогтоомжид саналаа хүргүүлж, СЗХ-ны дэргэдэх Бичил Санхүүгийн Бодлогын Зөвлөлөөр дамжуулж салбарт тулгамдаж байгаа асуудлуудаа тухай бүр хэлэлцэж хамтран ажиллаа. Жишээ нь банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх хуваарийг хойшлуулах, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд гишүүдийн саналыг хүргүүлж амжилтай ажиллалаа.

МББСХолбоо эдийн засгийн шинэ нөхцөл байдалд санхүүгийн хүртээмжийг улам нэмэгдүүлэн хөгжүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ техник технологийн шийдэл, эх үүсвэр татах боломжуудыг дэмжих зэрэгт онцгойлон анхаарч, улмаар үйл ажиллагааны өртөг бууруулах, комплаенс, нийгмийн хариуцлагыг хангасан тогтвортой санхүүгийн салбар байлгахад онцгой анхаарч бодит үр дүнд хүргэхийн төлөө ажиллах болно.

Холбооны үйл ажиллагааг бодлогоор хангаж байдаг УЗ гишүүд, нэгдмэл чанараа хадгалж ирсэн холбооны нийт гишүүн ББСБууд, өдөр тутмын ажлыг гүйцэтгэж байдаг Ажлын алба, бидэнтэй хамтран ажилладаг байгууллагууд, компаниуддаа чинь сэтгэлийн талархал дэвшүүлж ажил үйлс тань амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн: Монголын ББСБ-уудын Холбооны Ерөнхийлөгч З. Алтанзул

# ХОЛБООНЫ ТУХАЙ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо нь /МББСБХ/ 2002 онд байгуулагдсан ба ББСБ-уудыг сайн дураар нэгтгэсэн,ардчилсан засаглалтай, бие даасан, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

МББСБХ нь сүүлийн 20 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн, тогтвортой явуулж ирсэн ба гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хүсэл зоригийг төрийн эрх барих байгууллагын өмнө төлөөлөх, гишүүдийг зөвлөмж мэдээллээр хангах, боловсон хүчнийг сургах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, олон нийтэд сурталчлах, хууль хяналтын байгууллага, гадаад дотоодын харилцагч түншүүдтэй хамтран ажиллах, ББСБ-ын салбарыг хөгжүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг үндсэн чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

2021 оны байдлаар МББСБХ нийт 182 ББСБ-ууд гишүүнчлэлтэй бөгөөд салбарын

**НИЙТ АКТИВЫН**

**69%**

**НИЙТ ЗЭЭЛИЙН**

**70%**

**ЗЭЭЛДЭГЧИЙН**

**51%**

төлөөлж байна.

## АЛСЫН ХАРАА

Хүчирхэг бичил санхүүгийн үйлчилгээ болон түншлэлийн нэгдмэл байдлаар орлогыг нэмэгдүүлж, Монгол орныхоо нийгэм, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын санхүүгийн зах зээлд эзлэж буй ББСБ-ын салбарын байр суурийг улам бэхжүүлэн хөгжүүлэх, олон улсын түвшинд гарган үйл ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол улсын нийгэм эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг улам дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх, бичил болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидэд бодит дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ЗОРИЛТ

- ББСБ-уудын хууль ёсны эрх, нийтлэг ашиг сонирхолыг төлөөлөн хамгаалах, эрх бүхий байгууллагын өмнө төлөөлөх
- ББСБ-уудыг гадаад, дотоодын банк, санхүүгийн салбарын холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, ББСБ-уудын дундын мэдээллийн зохих санг буй болгох
- ББСБ-уудын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг сурталчилах, олон нийтэд таниулах
- ББСБ-уудын ажилтнуудыг сургах, боловсон хүчнийг чадавхижуулах
- ББСБ-ын үйл ажиллагааны стандартуудыг тогтоож хөгжүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулах

# МББСБ-ЫН ХОЛБООНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МОНГОЛЫН БАНК БҮС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

МББСБХ нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, ажлын алба гэсэн үндсэн бүтэцтэй байна.

## Бүх гишүүдийн хурал:

МББСБХ-ны эрх барих дээд байгууллага нь “Бүх гишүүдийн хурал” байх бөгөөд, холбооны бүтэц зохион байгуулалт, дүрэм, жилийн төсвийг батлах, Хяналтын зөвлөлийн зөвлөлийн гишүүнийг сонгох, ажлын тайланг хэлэлцэх, дүгнэлт өгөх гэх мэт бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## Хяналтын зөвлөл:

Хяналтын зөвлөл нь: 3 хүний бүрэлдэхүүнтэй, Холбооны гишүүдээс 3 жилийн хугацаатай сонгогдоно. Зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүд өөрсдөө сонгоно. 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Хяналтын Зөвлөлийн гишүүн нь: Холбооны гишүүн ББСБ-г төлөөлөх бүрэн эрх бүхий удирдах дээд албан тушаалтан, банк санхүүгийн салбарт 2-с доошгүй жил удирдах албан тушаал хашиж байсан салбарын хууль, эрх зүйн мэдлэгтэй эдгээр шаардлагыг хангасан албан тушаалтан байна.

Хяналтын зөвлөл нь: МББСБХ-ны дүрэм, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих, өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## Холбооны Удирдах зөвлөл:

Удирдах Зөвлөл нь 13 гишүүнтэй байх бөгөөд хамгийн багадаа 6 гишүүн нь улиран 2 жилийн хугацаатай сонгогдоно.Удирдах Зөвлөлийн гишүүд нь Хяналтын Зөвлөлийн гишүүдтэй адил шаардлагыг хангасан албан тушаалтан байна.

Удирдах Зөвлөл нь: Холбооны үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах,

Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх Захиралыг сонгох, чөлөөлөх түүний дор ажиллах ажлын албаны бүтэц зохион байгуулалт төсөв, тайланг хэлэлцэх батлах эрхийг хэрэгжүүлнэ.

Мөн холбооны гишүүдийг шинээр элсүүлэх, чөлөөлөх, гишүүдийн татвар төлөх журмыг тогтоох, ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих эрхийг хэрэгжүүлнэ.

## Холбооны Ерөнхийлөгч:

Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны Удирдах зөвлөлийн хурлыг даргалах, Холбоог гадаад, дотоодод төлөөлөх, Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн холбооны гүйцэтгэх захиралтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажилуулах, дүгнэх, Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, бэлтгэлийг хангуулах эрхийг хэрэгжүүлнэ.

Ерөнхийлөгч нь Банк, санхүүгийн салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан туршлагатай, үндсэн бизнес нь ББСБ, зохион байгуулах, манлайлах чадвартай, ажлын идэвхи санаачлага сайтай байх гэх мэт үндсэн шаардлагыг хангасан байх.

## Холбооны Гүйцэтгэх захирал:

Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн хурлаас 2 жилийн хугацаагаар томилон ажиллуулж болох бөгөөд улируулан томилж болно.

Гүйцэтгэх захирал нь: Холбооны ажлын албыг удирдах, Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, улиралд нэг удаа холбооны үйл ажиллагааны явцын талаар “Удирдах Зөвлөл”-д илтгэн тайлагнах, шаардлагатай бол Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж ажиллана.

# МББСБ-ЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ БҮТЭЦ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО



# МББСБ-ЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ БҮТЭЦ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

## УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Холбооны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал бөгөөд гишүүдийн төлөөллөөс бүрдсэн Удирдах зөвлөлийн 13 гишүүн, Хяналтын зөвлөлийн 3 гишүүн, үйл ажиллагааны байнгын 6 хорооны бүтэцтэй байна. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг Удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэр, өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэх захирлаар удирдуулсан ажлын алба явуулж байна.

- БИД ББСБ
- Бичил глобус финанс ББСБ
- Инвескор ББСБ
- Кловер ББСБ
- Кредитех СТМ ББСБ
- Очир Ундраа ОМЗ ББСБ
- Про кредит ББСБ
- Сэкюр финанс ББСБ
- Төв хөгжил ББСБ
- Тэнгэрлиг авто финанс ББСБ
- Транскапитал ББСБ
- Хөгжил Финанс ББСБ
- Централ капитал ББСБ

## ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Холбооны дүрмийн дагуу удирдах зөвлөлийг 2 жилийн хугацаатайгаар, хяналтын зөвлөлийг 3 жилийн хугацаатайгаар бүх гишүүдийн хурлаас томилдог. Холбооны ерөнхийлөгчийг Удирдах зөвлөлийн гишүүдээс 3 жилийн хугацаатайгаар томилдог.

- Жуниор натур инвестмент ББСБ
- Солонго капитал ББСБ
- Шийдэл финанс ББСБ

# МББСБ-ЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ БҮТЭЦ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

## АЖЛЫН АЛБА



Гүйцэтгэх захирал
**А.МӨНХБАЯР**

Үйл ажиллагааны менежер
**Б.НАСАНДЭЛГЭР**

Маркетингийн менежер
**Г.БАТ-ИРЭЭДҮЙ**

## ТӨР, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороотой ББСБ-уудын үйл ажиллагааны тогтвортой хөгжлийг хангах, Монгол Улсын нийгэм, эдийн засагт оруулж буй үр нөлөөг дээшлүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна. Санамж бичгийн хүрээнд хууль эрхзүйн орчинг сайжруулах, стратеги бодлогын баримт бичиг боловсруулах, ББСБ-ын тогтвортой өсөлтийг хангах, банк бус санхүүгийн салбарын боловсон хүчнийг сургах, чадавхижуулах чиглэлд хамтран санамж бичгийн хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна.




*Монгол Улсын засгийн газар "ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЖ, ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ"-нд ББСБ-ын оролцоог хангах талаар ажил хэрэгч яриаг өрнүүллээ.*

УИХ-ын дарга Г.Занданшатар банк, санхүүгийн салбарынхантай уулзлаа. Уулзалтад Холбооны УЗ-н гишүүд оролцож банк, санхүүгийн салбарт тохиолдож буй сорилт болон хөгжлийн бодлого, үйл ажиллагааны талаар ярилцлаа.



*Банк санхүүгийн салбарын өнөөгийн байдал сэдэвт уулзалт*

# ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

## МББСБХолбоо болон Монголын тос холбоо хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурлаа

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо стратеги бодлогынхоо хүрээнд харилцагчийг хамгаалах зарчим, комплаенс, тогтвортой хариуцлагатай санхүүгийн хөгжлийг дэмжиж ажилладаг. Энэ удаагийн хамтарсан тунхаг бичгийн зорилго нь Монгол Улсын санхүүгийн системд, түүн дотроо ББСБ-ууд зохистой санхүүжилтийн үзэл баримтлалыг байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогоор дамжуулан нэвтрүүлэх аливаа санхүүгийн шийдвэр гаргахдаа байгаль эх дэлхий, хүрээлэн буй орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай байх зарчмыг удирдлага болгож ажиллахад байгаа юм.



Мөн банк бус санхүүгийн салбарын нийт ажилтан, харилцагчид, хамтран ажиллаж буй байгууллагууддаа байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг удирдах болон хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний ач холбогдлын талаар мэдээлэл, ойлголт өгч, тогтвортой үр өгөөжийг түгээн дэлгэрүүлэхэд хамтран ажиллах юм.

## МББСБХолбоо болон санхүүгийн боловсрол HUB ТББ хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа

**Санамж бичгийн зорилго:** Талууд нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн банк бус санхүүгийн салбарын шаардлагад нийцсэн хүний нөөцийг чадавхижуулан хөгжүүлэх замаар Монгол Улсын нийгэм, эдийн засагт гарч буй их хэмжээний үргүй зардлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах, комплаенсийн ажилтнуудын бүтээмжийг дээшлүүлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хүртээмжийг сайжруулах, сургалтын чанар чансааг дээшлүүлэх зорилгоор энэхүү санамж бичгийг байгуулав.



# ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

## МББСБХолбооны ерөнхийлөгч З.Алтанзул, “МОНИ МАРКЕТ ФАНД” ХХК-н төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Цолмон нар харилцан ойлголцлын санамж бичгит гарын үсэг зурлаа.




Энэхүү санамж бичгийн зорилго нь Банк бус санхүүгийн байгууллагуудын олгож буй зээлийн хүүг бууруулах дунд хугацааны нэгдсэн зорилгын хүрээнд Мони Маркет Фанд ХХК-ийн цахим платформд суурилсан Репо зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, цаашлаад Монгол Улсын банкны бус санхүүгийн салбарт Мөнгөний захыг үүсгэхэд оршино.



## МББСБХолбоо болон Капитрон банк хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

Энэхүү санамж бичгийг байгуулснаар Монгол Улсын санхүүгийн зах зээлийн голлох хоёр салбарын хамтын ажиллагаанд гүүр болсон анхны үйл явдал болж байгааг онцлон холбогдох хууль, журмын хүрээнд хамтран ажиллахаа харилцан илэрхийллээ.

Хамтын ажиллагааны хүрээнд Капитрон банк банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээнд тулгуурлан бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл хураамжийн таатай нөхцөлийг холбооны гишүүд болон тэдгээрийн үйлчлүүлэгч, харилцагч нарт санал болгох замаар харилцагч төвтэй үйлчилгээний стандартыг нэвтрүүлэхээр зорьж байна.



# ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

2018-2020 онд Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан гишүүдэд талархал гардуулав.






# ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНЫГ САЙЖРУУЛАХ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

МББСБХ нь банк бус санхүүгийн салбарын үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, бодлого зохицуулалтын шийдвэр, эрх зүйн актын төсөл, түүнд оруулах санал өгөх, холбогдох төслийг боловсруулах, гишүүдийн эрх ашгийг илэрхийлсэн зохицуулалтыг эрх зүйн хэм хэмжээнд тусгуулах болон холбогдох хууль тогтоомжийг зохих ёсоор хэрэгжүүлэхийг шаардах зэргээр гишүүдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн оролцож, хууль тогтоогч болон зохицуулагчидтай хамтран ажилладаг.



- Дэлхий даяар тархаад буй “Ковид-19” цар тахалаас үүдэлтэйгээр ББСБ-уудад хууль эрх зүйн болон санхүүгийн тал дээр дэмжлэг хүссэн агуулга бүхий албан бичгийг удаа дараа СЗХ-нд хүргүүлсэн.

- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай” хуулийн 15.4-д дугаарт заасны дагуу 51 ББСБ-н аудитлагдсан тайланг Холбооны сайт дээр байршуулж СЗХ-нд хүргүүлсэн.

- ББСБ-уудын зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүү, шимтгэлийн талаарх мэдээллийг агуулсан санг бүрдүүлж Холбооны сайт дээр байршуулав.

- Монголбанкнаас гаргасан “Ковид-19 цар тахлын үед арилжааны банкуудад хэрэгжүүлэх зарим үйл ажиллагааны тухай” журманд ББСБ-уудын валют арилжааны гүйлгээ хийх эрхийг зөрчсөнийг эсэргүүцэн Монгол банк болон СЗХ-нд албан тоот илгээн тайлбар авч шийдвэрлүүллээ.

- ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гишүүн ББСБ-аас санал авч СЗХороонд өргөн бариад байна.

# ГАДААД ХАРИЛЦАА

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Бичил санхүүгийн төвийн /MFC/ албан ёсны гишүүний шугамаар ( ЭНЭ ЯМАР БАЙГУУЛЛАГА ВЭ) Холбооны гишүүн ББСБ-уудын олон улсын чуулга уулзалт, сургалт, семинарт хөнгөлөлттэй үнээр хамруулах, техникийн болон санхүүгийн дэмжлэг, мэдээлэл, арга зүйн туслалцаа авах, хөрөнгө оруулагч байгууллагуудтай холбоо, харилцаа тогтоох улмаар санхүүжилт татах боломжуудыг эрэлхийлэн ажиллаж байна. Европын сэргээн босголт хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Азийн хөгжлийн банк, МикроФинанза рэйтинг зэрэг байгууллагуудтай хөрөнгө оруулалт, сургалт, санхүүжилт, зөвлөгөө мэдээлэл авах чиглэлд хамтран ажиллаж байна.

МББСБХ, СЗХ болон гишүүн байгууллагуудын төлөөлөл Тайландын нийслэл Банкок хотод 2020 оны нэгдүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд Азийн санхүүгийн байгууллагуудын форумд амжилттай оролцлоо. Тус форум нь тогтвортой, байгаль орчинд ээлтэй, үр нөлөөтэй санхүүжилт үзэл баримтлалын хүрээнд болсон бөгөөд хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалт татагч, зээлдэгч, зээлдүүлэгч болон бичил санхүүгийн байгууллагууд, баталгаа гаргагч, олон улсын хөгжлийн байгууллага, техникийн туслалцаа үзүүлэгч зэрэг байгууллагын 550 гаруй төлөөлөгч оролцсон бөгөөд оролцогчид хоорондоо бизнесийн харилцаа холбоо үүсгэх, туршлага солилцох, яриа хэлэлцээ хийх зэрэг өргөн боломжтой болсоноороо онцлог юм.

## БОЛОВСОН ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ

ББСБ-ын салбарын боловсон хүчнийг чадавхижуулах зорилгын хүрээнд сургалтын чиг үүргийг МББСБХ хэрэгжүүлж байгаа төдийгүй уг зорилтынхоо хүрээнд стандарт, хэрэгцээт, гадаад гэсэн үндсэн гурван төрлийн сургалтыг төлөвлөн, модуль тус бүрийг тусгайлан боловсруулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран онолд тулгуурласан сургалтуудыг зохион байгуулж байна.

ББСБ-уудын хэрэгцээ шаардлагад үндэслэн тухайн жилийн сургалтын төлөвлөгөө, сургалт тус бүрийн модуль зэргийг боловсруулан, бүх гишүүдийн хурлаар батлуулан ажиллаж байна. Төрийн байгууллагуудын сертификатжуулсан сургалтуудыг тогтмол зохион байгуулж, гишүүн байгуллагуудын комплаенс, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хангуулан ажиллахад ихээхэн анхаарсан.

Норна экспонг ХХК-тай хамтран ББСБ-ын маркетингийн менежер нарт зориулан “Сошиал маркетинг борлуулалт хийх ур чадвар олгох нь” сургалтыг 2021 оны 03-р сарын 19-нд зохион байгуулж 12 ББСБ-ын 16 менежерүүд хамрагдсан.

ОУСК-аас “Авлага санхүүжүүлэх ажиллагаанд технологийн шийдэл ашиглах нь сэдэвт вебинарыг зохион байгуулж 33 ББСБ-ын 23 ажилтан албан хаагч нар хамрагдав.

Банк санхүүгийн академитай хамтран Комплаенс ба ёс зүй онлайн сургалтыг удаа зохоин байгуулж 121 хүн амжилттай хамрагдлаа.




Банк санхүүгийн академитай хамтран Банк санхүүгийн ажилтны ХАБЭА онлайн сургалтыг зохоин байгуулж 12 хүн амжилттай хамрагдлаа.




Банк санхүүгийн академитэй хамтран ББСБ-ын зээлийн эдийн засагч нарт зориулсан 5 өдрийн онлайн сургалтыг 2021 оны 04-р сард зохион байгуулж 17 ББСБ-ын 25 зээлийн ажилтнууд хамрагдлаа.

2021 оны 05-р сарын 21-нд ОУСК-аас зохион байгуулсан Факторингийн сургалтанд 6 гишүүн байгууллагын 11 ажилтан хамрагдлаа.

2021 оны 06-р сарын 19 -нд ОУСК-аас зохион байгуулсан Чанаргүй зээлийн гарын авлага сэдэвт онлайн вебинар зохион байгуулагдаж 22 ББСБ-ын 44 ажилтан хамрагдсан.

МББСХолбооноос 2021 оны 05-р сарын 27-нд ББСБ-ын нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж 49 ББСБ-ын 57 нягтлан бодогч нар хамрагдсан.

СЗХ-ны МУТСТ хэлтэстэй байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд Холбооны сургагч багш нартай хамтран “МУТСТ-Дотоод хяналтын хөтөлбөр боловсруулах нь” онлайн хэлэлцүүлэгийг зохион байгуулж 35 ББСБ-ын 41 комплаенс хариуцсан мэргэжилтнүүд оролсон.



# СУРГАЛТ



2021 оны 09-р сарын 08-10-ны өдрүүдэд СЗХ-той хамтран шинээр тусгай зөвшөөрөл авсан ББСБ-ын гүйцэтгэх захирлуудад эрх олгох сертификатжуулсан сургалтыг амжилттай зохион байгуулж 21 ББСБ-ын 26 гүйцэтгэх удирдлагууд хамрагдсан.



Санхүүгийн боловсрол HUB -тай хамтран ББСБ-ын удирдах ажилтнуудад зориулсан “Комплаенс-Удирдах ажилтны манлайлал” сургалтыг зохион байгуулж 13 ББСБ-ын 15 удирдлагууд оролцсон.

ББСБ-ын харилцагч үйлчилгээний ажилтнуудад зориулан “Харилцагчийн үйлчилгээний ёс зүй, түүний стандарт” сэдэвт 2өдрийн онлайн сургалтанд 21 ББСБ-ын 26 ажилтанууд хамрагдлаа.




Зээлийн ажилтны сургалтын ахисан шат буюу “Зээлийн эрсдлийг удирдахуй” сургалтыг Санхүүгийн боловсрол HUB-тай хамтран зохион байгуулж 19 ББСБ-ын 23 зээлийн мэргэжилтнүүд хамрагдлаа.




2021 оны 10-р сарын 15-нд ОУСК-аас “Авлага худалдан авалтыг хуулийн хүрээнд ойлгох нь” сэдэвт онлайн вебинар зохион байгуулж гишүүн байгууллагын 26 хүн хамрагдаж мэдээлэлээ солилцлоо.

Мөн ОУСК-аас “Ногоон бонд гаргах үйл ажиллагаа, үнэ тогтолт, Хөрөнгө оруулагчдын зүгээс тавигдах шаардлага” хэлэлцүүлэг явагдаж 15 ББСБ-ын 16 хүн хамрагдсан.



Монголын ББСБ-уудын Холбооноос нягтлан бодогч нарт зориулан татварын хуулийн шинэчлэлт Татварын бүртгэл хэрхэн хийх практик сургалт зохион байгуулж 51 ББСБ-ын 55 нягтлан бодогч нар хамргадсан.



# СУРГАЛТ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Санхүүгийн боловсрол HUB-тай хамтран Комплаенсын ажилтнуудыг мэргэшүүлэх 5 хагас өдрийн онлайн сургалтыг зохион байгуулж 12 ББСБ-ын 15 хүн хамрагдсан.




Бизкон аудит ХХК-тай хамтран Дотоод хяналтын ажилтнууд, дотоод аудиторуудад зориулаан " Аудитаар илэрдэг алдаа зөрчлүүд сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулсан.




Хүний нөөцийн ажилтнуудад зориулан хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэйгээр холбогдуулан 2 өдрийн онлайн сургалтыг 2021 оны 11 сарын 17-18 ны өдрүүдэд зохион байгууагдав.




Комплаенсийн эрсдэлийг удирдахуй панел хэлэлцүүлэг Панел хэлэлцүүлгийг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн боловсролын HUB, МББСБХолбоо, Монголын комплаенсийн холбоо, Олон улсын комплаенсийн холбоо, И Зэт Би ББСБ хамтран зохион байгуулсан. СЗХ-ны зохицуулалттай 6 салбарын удирдлага төлөөллүүд дараах сэдвийн хүрээнд панел хэлэлцүүлэг өрнүүлсэн.

- Комплеансын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх
- Харилцагчийг таньж мэдэх ажиллагаа, анхаарах асуудлууд: /УТНБЭ, эцсийн өмчлөгчийг тодорхойлох, халхавч байгууллагууд, өндөр эрсдэлтэй салбар/
- Сэжигтэй үйлдэл , гүйлгээг илрүүлэх, мэдээлэх нь сэдвээр санал солилцлоо.







# ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНОЛОГИЙН САЙЖРУУЛАЛТ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Холбооны www.bbsb.mn цахим хуудсаар Холбооноос зохион байгуулж буй ажил, мэдээ мэдээлэл, тайланг сайтаараа дамжуулан хүргэж байна.



"Үндэсний дата төв" УТҮГ-аас үзүүлж буй "Хур", Танилт нэвтрэлтйн дан системийн төлбөрийг хойшлуулах, үнэ өөрчлөлтөнд ББСБ-уудас ирсэн саналыг тусгаж албан тоот хүргүүлсэн.

"Гайхам" ХХК компанитай Холбооны гишүүн байгууллагуудад тэдгээрийн бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, барьцаалсан машин тоног төхөөрөмжийн хяналтыг сайжруулах ,тээврийн хэрэгслийг хянах үйлчилгээг (тоног төхөөрөмж болон үйлчилгээ) нийлүүлэх ба хяналтын үйлчилгээг хийхэд хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

"Юу Эн Ай Ти" ХХК -с гаргаж буй үйлчилгээг гишүүн ББСБ-уудад "Үйлчилгээ болон Хэрэгцээт системийн, хөгжүүлэлт"-ийг хөнгөлөлттэй үнээр хийхээр санамж бичиг байгуулсан.

"Интерактив Би Ай" компанитай уулзаж тус компанийн үйлчилгээг авдаг ББСБ уудын саналыг хүргэж, уг компаниас гарах шинэ программыг хөнгөлөлттэй үнээр авхаар гэрээгээ шинэчлэн байгуулав.



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Гишүүн ББСБ-уудын үйл ажиллагааг олон нийтэд эергээр таниулах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор нийгэмд чиглэсэн олон үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2021 онд “Амьдрал бэлэглээ” аян, “Бид санхүүч гэр бүл” гар зургийн уралдаан зэргийг зохион байгуулсан.

## АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ АЯН

Цусны донорын үйлсийг дэмжигч шилдэг байгууллага

Холбооны гишүүн ББСБ-уудын хамт олон гурван жилийн хугацаанд 600 гаруй ажилтан албан хаагч нэгдэж 1800 хүнд амьдрал бэлэглэж “цусны донорын үйлсийг дэмжигч шилдэг байгууллагаар” шалгарлаа. Амьдрал бэлэглээ аянд нэгдсэн ачтан та #донортабаатар юм шүү.






2021 онд Холбооны гишүүн 12 ББСБ-н 130 ажилтан албан хаагч нэгдэж 400 хүнд амьдрал бэлэглэлээ.



## ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

Хүртээмжтэй Санхүү Аяны хүрээнд БИД САНХҮҮЧ ГЭР БҮЛ сэдэвт гар зургийн уралдаанд 3 насны ангиллаар явагдаж 80 хүүхэд бүтээлээ ирүүлсэн.

Ивээн тэтгэгчээр оролцож хамтран ажилласан Газар капитал партнерс ББСБ Кловер ББСБ




## ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монголын ББСБ-ын Холбооноос жил бүр зохион байгуулдаг оны ШИЛДЭГ ББСБ-уудаар зочилж туршлага судалдаг “ББСБ-ТУР 2021” 7 дахь жилдээ зохион байгуулагдсан. Энэ жилийн Тур аяллыг анх удаа цахимаар зохион байгуулж 120 гаруй хүн оролцов.Энэхүү аяллын зорилго нь ББСБ- уудаар аялж тэдгээрийн үйл ажиллагаатай нь танилцан, тухайн ББСБ-ын соёл бүтээгдэхүүн үйлчилгээний тэргүүн туршлагыг нүдээр харах боломжийг гишүүддээ олгохоор зорьдог.



Холбоо нь гишүүддээ олон улсын болон дотоодын эдийн засаг, банк санхүүгийн салбарын холбогдолтой төрөл бүрийн мэдээ мэдээллийг цаг тухайд нь оновчтой хүргэх, олон улсын банк, санхүүгийн байгууллагын тэргүүн туршлага, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн салбарын өнөөгийн болон хэтийн төлөв байдлын талаарх судалгаа тайланг боловсруулан түгээж, холбооны гишүүдийн хооронд үр ашигтай мэдээллийн системийг бүрдүүлж харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх

## САЛБАРЫН ЗАХИРЛУУДЫН ЯРИЛЦЛАГА



СЗХ-ны ББСБ-н газрын дарга Б.Итгэлсүрэн ББСБ-уудаас бизнесийн зээлийг онлайнаар авах боломж бүрдэнэ




“БИД” ББСБ-ын үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, МББСБХ-ны удирдах зөвлөлийн гишүүн А.Алтансүх: Банк бус санхүүгийн салбарт ирээдүй их байна.



Төв хөгжил” ББСБ-ын гүйцэтгэх захирал Б.Гэрэлмаа: Маргаашийг төлөвлөхгүй өнөөдрийг устгах нь мөхөлд хүргэнэ.



“Мобифинанс” ББСБ-ын гүйцэтгэх захирал Ш.Оюунчимэг Сэтгэлгээний хувьслыг түүчээлнэ



“ЛэндМН ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Удвал Монголчууд дэлхийн мэдээллийн технологийн салбарт гарах боломжтой




“Гялс кредит” ББСБ-ын гүйцэтгэх захирал Ч.Дашсүрэн: Санхүүгийн хэрэглэгч болсноос хойшхи хугацааны мэдээллийг онооны системээр дүгнэх нь илүү оновчтой.



“Төв хөгжил ББСБ-ын 20 жилийн ойн хүрээнд хийгдсэн онол практикийн бага хурал боллоо.






Финтек бидэнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн сэдэвт тедевикийн



Британика нэвтэрхий толь: Холбооны товч мэдээллийг байршуулав.




Санхүүгийн Хөтөч Сэтгүүл: Холбооны логог сэтгүүлийн нүүрэнд байршуулав.

## “АЛТАН-ОД 2021” ШАГНАЛЫН ЭЗЭД

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо нь 2021 оныг нийт хамтран ажиллагч байгууллага, түүний харилцагчид хүргэх үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэхийн тулд “Хүртээмжтэй Санхүүгийн жил” болгон зарласан билээ. Энэхүү аяны хүрээнд өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ ялгарч 2.8 сая харилцагч хэрэглэгчиддээ хүрч үйлчилсэн нийт 534 ББСБ-ын, 3400 ажилтанууд дундаас дараах Шилдэг Банк Бус Санхүүгийн Байгууллага, Шилдэг ажилтнуудыг шалгаруулж “АЛТАН




Шилдгийн шилдэг 5 тэрбумаас дээш:
**БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ**




Шилдгийн шилдэг 5 тэрбумаас доош:
**ГЭРЭЛ ФИНАНС ББСБ**




**Оны шилдэг нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч:**
**ТРАНСКАПИТАЛ ББСБ**




**Оны шилдэг Санхүүгийн хүртээмжтэй 5 тэрбумаас дээш:**
**ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ**




**Оны шилдэг Бүтээгдэхүүн үйлчилгээтэй 5 тэрбумаас дээш :**
**ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ**




**Оны шилдэг Бүтээгдэхүүн үйлчилгээтэй 5 тэрбумаас доош :**
**СЭНД ЭМ ЭН ББСБ**




**ОНЫ ШИЛДЭГ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ**
/5 тэрбумаас доош/




**ОНЫ ОНЦЛОХ ХҮН Д.БАЯРСАЙХАН**
Санхүүгийн зохицуулах хорооны дарга




**ОНЫ ШИЛДЭГ НЯГТЛАН БОДОГЧ ШАГНАЛЫН ЭЗЭД**

"Бид" ББСБ С.Дуламсүрэн
"Централ Капитал" ББСБ Г.Бямбадорж
"Сэкюр Финанс" ББСБ Г.Өлзийжаргал






**ОНЫ ШИЛДЭГ ЭДИЙН ЗАСАГЧ ШАГНАЛЫН ЭЗЭД**

"Сэнд МН" ББСБ М.Зулаа
"Их Гифт Финанс" ББСБ С.Дагвасүмбэрэл
"Газар Капитал Партнерс" ББСБ Б.Эрдэнэжаргал




**ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТАН ШАГНАЛЫН ЭЗЭД**

"Хас Хаан" ББСБ Б.Цэцэгмаа
"Бичил Глобус Финанс" ББСБ Ж.Ганбаяр




**ОНЫ ШИЛДЭГ САЛБАРЫН ЗАХИРАЛ ШАГНАЛЫН ЭЗЭД:**

"Бид" ББСБ Э.Батсүх
"Газар Капитал Партнерс" ББСБ М.Алтансүх
"Транскапитал" ББСБ Б.Нямхүү




Оны шилдэг нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч:
ТРАНСКАПИТАЛ ББСБ




Оны шилдэг нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч:
ТРАНСКАПИТАЛ ББСБ




ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ




Оны шилдэг Санхүүгийн хүртээмжтэй 5 тэрбумаас дээш:
ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ




Оны шилдэг Бүтээгдэхүүн үйлчилгээтэй 5 тэрбумаас дээш :
ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ




Оны шилдэг Бүтээгдэхүүн үйлчилгээтэй 5 тэрбумаас дээш :
ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ




Оны шилдэг Бүтээгдэхүүн үйлчилгээтэй 5 тэрбумаас доош :
СЭНД ЭМ ЭН ББСБ




Оны шилдэг Бүтээгдэхүүн үйлчилгээтэй 5 тэрбумаас доош :
СЭНД ЭМ ЭН ББСБ

# МАРКЕТИНГ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

## ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН ХӨНГӨЛӨЛТ




## МЭНДЧИЛГЭЭ




## ХОЛБООНЫ ТАЙЛАН, ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭНЭ ХЭВЛЭВ.




## ХОЛБОО МАКС ЦАМХАГТ НҮҮЖ ИРЛЭЭ




Холбоо Макс цамхагт нүүж ирлээ

# ББСБ -ЫН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Холбооны гишүүн ББСБ-ууд санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн шуурхай болгож буй аппликэйшн.

| | |
|---|---|
| Мобифинанс | **Monpay** |
| Нөмөр кредит | **Numur** |
| Централ кредит | **Kmobi** |
| Монголиа импакт фина | **Qmoni** |
| Инвескор хэтэвч | **Pocket.mn** |
| Ардкредит | **Ard app** |
| Жи Эс Би Капитал | **GSB capital** |
| Зээл Эм Эн платформ | **Zeel.mn** |
| Лэндмн | **Lendmn** |
| Ти финанс | **T-finance** |
| Соно финтек | **Sono Mongolia** |
| Говь финанс | **Cash One** |
| Ашид капитал | **Simple** |
| Хатан суудал инвест | **Zeely** |

| | |
|---|---|
| Смарткапитал фанд | **Mycredit.mn** |
| **Очир ундраа ОМЗ** | **Opay** |
| **Омни капитал** | **Moni digital** |
| **Нэт капитал финанс** | **Netapp MN** |
| **Таван богд финанс** | **PayOn.mn** |
| **Сэнд эм эн** | **sendmn** |
| **Хас хаан** | **Хас хаан** |
| **Солонго капитал** | **100K.mn** |
| **Гэрэлфинанс** | **Gerel** |
| **Микрокредит** | **Micro Credit** |
| **Начин заан финанс** | **Naizly.mn** |
| **Нэйшнл кредит** | **tenlend** |

# БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУРААНГУЙ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ууд нь үндсэн 9 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн зах зээлд нийт 534 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагийн 92,8 хувь нь буюу 496 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 27,3 хувь нь буюу 146 ББСБ гадаад валютын арилжааг дагнан болон хавсран эрхэлж байна.

ББСБ-ууд нь Санхүүгийн зохицуулах хороноос авсан 11 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд санхүүгийн тайланг улирал бүр хүргүүлж, зайны болон газар дээрх хяналтын хүрээнд ажилладаг.

## ББСБ-уудын тархалт

Монгол улсын 21 аймагт ББСБ-ын үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч дийлэнх 451 ББСБ буюу 84.5% нийслэл Улаабаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Орон нутгийн хэмжээнд салбаруудын 29.6% буюу 98 салбар иргэдэд банк бус санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. Дараах зурагт ББСБ-уудын байршлын тархалтыг Монгол улсын газрын зураг болон графикаар үзүүллээ.

### ББСБ-ЫН ТАРХАЛТ 2021

**Нийт ББСБ**
**Улаанбаатар 451**
**Орон нутагт 98**

**Гишүүн ББСБ**
**Улаанбаатар 195**
**Орон нутагт 74**

| | |
|---|---|
| БАРУУН БҮС | 11 ББСБ<br>11 САЛБАР |
| ХАНГАЙН БҮС | 25 ББСБ<br>31 САЛБАР |
| ТӨВИЙН БҮС | 34 ББСБ<br>41 САЛБАР |
| БАРУУН БҮС | 13 ББСБ<br>15 САЛБАР |

### ББСБ ЗАХ ЗЭЭЛ







**Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй 532 ББСБ нийт 295 салбартай. Холбооны гишүүн ББСБ-н хувьд салбар нэгжийн тоо Улаанбаатар хотод 195, Хөдөө орон нутагт 74 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.**

# БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУРААНГУЙ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /давхардсан тоогоор/



# ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор ББСБ-уудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын харилцагчдын тоо өмнөх оноос 69.5%-иар нэмэгдэж 4.8 саяд хүрсэн байна. Үүнийг дагаад нийт зээлийн өсөлт өмнөх оноос 51.6%-иар өсөж 2 их наяд хүрсэн өсөлттэй байна.2021 оны байдлаар 3976 ажилтан албан хаагч Банк бус санхүүгийн салбарт ажиллаж байна.

**Нийт зээл өсөлт**

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 51.6% буюу 685 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны жилийн эцсийн байдлаар 2 их наяд төгрөгт хүрсэн байна. Зээл 2012,1 Зээлийн өсөлт 51.6%




**Харилцагчдын тоо**

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 69.5% -иар өсөж 4.8 саяд хүрсэн байна.

Харилцагчдын тоо: 4.8 сая Харилцагчдын тоо өсөлт: 69.5%




**Ажилчдын тоо**

Нийт ажилчдын 58.7% нь буюу 685 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны жилийн эцсийн байдлаар 2 их наяд төгрөгт хүрсэн байна. Зээл 2012,1 Зээлийн өсөлт 51.6%




## ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө

Сүүлийн 6 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2016 оны мөн үед 787.2 тэрбум байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 35%-иар өсөж 2.7 их наяд төгрөгт хүрчээ.






# ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

Сүүлийн жилүүдэд ББСБ-уудын зах зээлд нийлүүлж буй зээлийн бүтээгдэхүүний хэмжээ тасралтгүй өсөж байгаа ба 2021 онд салбарын цэвэр ашгийн хэмжээ өмнөх оноос 35.7% хувиар өсөж 210 тэрбумд хүрсэн дүнтэй байна. 2021 оны байдлаар ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.7 хувьд хүрч өмнөх оноос 0.1 пунктээр буурсан, 2017 оноос 1.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.







## ББСБ-ын хүртээмж, хүн амын үзүүлэлтээр

ББСБ-уудын нийт харилцагчдын 52.5 хувь нь эмэгтэй, 47.5 хувь нь эрэгтэй байна. Нийт зээлдэгчдийн 58 хувь нь 18-35 насны, 25.5 хувь нь 36-45 насны, 13.5 хувь нь 46-55 насны, үлдсэн буюу 3 хувь нь 55-аас дээш насны хүмүүс байна.






# ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО




**ББСБ-ийн зээлдэгчид /насны бүлгээр/**




**Боловсролын түвшингээр**

Дээд боловсролтой иргэд бусад бүлэгтэй харьцуулахад ББСБ-аас илүү зээл авч байна. Тухайлбал 2019 оны байдлаар ББСБ-аас зээл авсан иргэдийн 58 хувь нь дээд боловсролтой, 9 хувь нь тусгай дунд боловсролтой, 29 хувь нь бүрэн дунд боловсролтой, 3 хувь нь дунд 1 хувь нь бага түвшний боловсролтой иргэд байна.



2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 538 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа 517 ББСБ-ууд байгаа ба энэ нь нийт зах зээлийн 97.2%-ийг эзэлж байна. Финтек зах зээлийн хувьд санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж үйл ажиллагаа явуулж буй ББСБ тоо 15 байгаа зээлдэгчдийн 72.6%, нийт зээлийн 15%, мөнгөн хөрөнгийн 15.6%-ийг эзэлж байна.

## Гишүүн ББСБ-ын зах зээлийн мэдээлэл




## Уламжлалт болон Финтек зах зээлийн мэдээлэл 2020 оны тоогоор

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 538 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба Уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа 527 ББСБ-ууд байгаа ба энэ нь нийт зах зээлийн 98%-ийг эзэлж байна. Зээлдэгчдийн тоо нь 154354 байгаа нь 36.7%-ийг эзэлж байна.Нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 41.9% байдлаар 1,233.1 тэрбум төгрөгт хүрсэн бол уламжлалт нь 1,010.1 тэрбумд хүрсэн 82%-ийг эзэлж байна. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл 336.5 тэрбум байгаа нь нийт зах зээлийн 92.4 эзэлж байна.

Финтек зах зээлийн хувьд санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж үйл ажиллагаа явуулж буй ББСБ тоо 11 байгаа нь зах зээлийн 2%, Зээлдэгчдийн 63.3%, нийт зээлийн 18%, мөнгөн хөрөнгийн 7.6%-ийг эзэлж байна.



# СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Холбооны гишүүн ББСБ-уудад чиглэсэн ажил, шинэ санал, санаачлагыг идэвхижүүлэх, холбооны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх гишүүн ББСБ-уудаас сэтгэл ханамжын судалгаа авав.

Судалгаанд холбооны гишүүн 122 ББСБ хамрагдсан бөгөөд зээл, төлбөрийн баталгаа гаргах, мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй, гадаад валют арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зэрэг тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-ууд хамрагдсан.

### Стратеги бодлогын чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

Холбооны стратеги бодлогын ажлуудад нийт ББСБ-ын 69.2% нь сайн ба маш сайн гэж дүгнэсэн ба өмнөх оны судалгаа нь 67% байсан үнэлгээ нь 2.2%-иар өссөн байна.




### Маркетинг, олон нийтийн арга хэмжээнд өгсөн үнэлгээ

Олон нийтэд чиглэсэн ажлуудад 70% нь сайн ба маш сайн гэж дүгнэсэн ба өмнөх оны судалгааны үнэлгээ 71% байсан нь 1%-иар буурсан үнэлгээтэй байна.




### Сургалтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

Сургалт, олон нийтэд чиглэсэн ажлуудад 79.5% нь сайн ба маш сайн гэж дүгнэсэн ба өмнөх оны судалгааны үнэлгээ 71% байсан нь 8.5%-ийн өсөлтийн үнэлгээтэй байна.




### МББСБХ-ны зах зээл, хууль эрх зүй болон салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл цаг тухайд нь хангалттай хүргэж байгаа эсэхд өгсөн үнэлгээ

Холбооноос мэдээ, мэдээлэл түгээх ажлын хувьд 71.3% нь Маш сайн ба сайн мэдээлэл өгдөг гэж үзсэн бол 27% нь дундаж, 1.6% нь муу гэж үзжээ. Холбооны зүгээс цаашид мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх, мэдээллийн сайтуудыг шинэчлэх сайжруулах, стратеги бодлого, хууль тогтоомж үйл ажиллагааны мэдээллийг оновчтой хүргэхээр төлөвлөн ажиллаж байна .




### МББСБХ-оос гишүүн ББСБ-уудтай харилцаа холбоотой ажиллаж, санал бодлыг сонсож нийтлэг эрх ашгийг хамгаалж чадаж байгаа эсэхд өгсөн үнэлгээ

Гишүүн ББСБ-уудын дуу хоолойг сонсож байгаа байдал нийтлэг эрх ашгийг хамгаалж байгаа байдлын хувьд 62% нь Маш сайн ба сайн явагдаж байна гэж үзсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 11%иар өссөн үзүүлэлтэй байна



# СУДАЛГАА

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

Q1: Танай ББСБ нь МББСБХолбооны гишүүн байгууллага болоод хэдэн жил болж байгаа вэ?




Q1: Танай ББСБ ямар төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа вэ?




Q3: Танай ББСБ-ын АКТИВЫН хэмжээ хэд байгаа вэ?




Q4: МББСБХолбооны СТРАТЕГИ, БОДЛОГЫН чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү.




Q5: МББСБХолбооны СУРГАЛТЫН хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү.




Q6: МББСБХолбооны ОЛОН НИЙТИЙН арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү.




Q7: МББСБХолбооны зах зээл, хууль эрх зүй болон салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл цаг тухайд нь хангалттай хүргэж байгаа эсэхд үнэлгээ өгнө үү.




Q8: МББСБХолбооноос гишүүн ББСБ-уудтай харилцаа холбоотой ажиллаж, санал бодлыг сонсож НИЙТЛЭГ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛЖ чадаж байгаа эсэхд үнэлгээ өгнө үү.




Q10: МББСБХолбооны үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Гишүүдийн жилийн хураамжийг актив хөрөнгөөр ангилж тодорхой хэмжээнд нэмэгдүүлэхийг та дэмжих үү.



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

# БИЗКОН АУДИТ ХХК

АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, АУТСОРСИНГ, СУРГАЛТ

2022 он 03 сар 04 өдөр Дугаар СТА-40/22 Улаанбаатар хот

**“Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо” ТББ-ийн**
**Гүйцэтгэх захирал А.Мөнхбаяр танаа**

**УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ**

Бид “Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо” ТББ-ийн (цаашид Байгууллага гэх) 2021 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарлыг татсан тодорхой асуудлуудыг та бүхэнд албан ёсоор танилцуулах шаардлагатай гэж үзэж энэхүү тайланг бэлтгэлээ. Бидний үзэж байгаагаар тайланд тусгагдсан энэ асуудлуудын талаар нэн даруй арга хэмжээ авбал зохино.

Тус байгууллагын 2021 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитын зорилго нь санхүүгийн тайлан, дуусгавар болсон жилийн үр дүнд дүгнэлт гаргах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.

Бид тусгагдсан асуудлуудын талаар та бүхний тайлбаруудыг хүндэтгэн хүлээн авах болно. Та бүхэнд тодруулга тайлбар шаардлагатай бол бидэнтэй эргэлзэлгүй холбоо бариарай. Ялангуяа, бид тохиролцсон зөвлөмжүүдийг гүйцэтгэх ажлын явцын талаар бидэнтэй байнга холбоотой байвал талархах болно.

Бид энэ завшааныг ашиглан аудитын ажлын явцад туслалцаа үзүүлсэн болон хамтран ажилласан явдалд талархал илэрхийлье.

**Хүндэтгэсэн,**

**ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ** БИЗКОН АУДИТ ХХК BIZCON AUDIT LLC УЛААНБААТАР ХОТ ТТГ4917 Ш.Z704404 **Л.ОТГОНБАЯР**

Монгол Улс, Улаанбаатар-210646, Чингэлтэй дүүрэг, Найман шарга, “Бизкон Аудит” ХХК-н байр, ш/х 46-845,
[УТАС/ФАКС: 976-70119107, 976-11-312773, 976-99119107, 976-96969607, 976-95959107]
[Э-шуудан: info@bizcon.mn. Вэб: www.bizcon.mn]

**“Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо” ТББ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд:**

“Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо” ТББ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, анхан шатны баримтад санхүүгийн тайлангийн аудит хийсэн болно. Санхүүгийн аудитын хүрээнд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга, гүйлгээ баланс, ерөнхий журнал, ХХБ-ны харилцах дансны хуулга, 2021 оны санхүүгийн холбогдолтой 3 боть зэрэг холбогдох материалуудын хүрээнд аудитыг 2022 оны 02-р сарын 22-аас 3-р сарын 03-ны хооронд явууллаа. Бид гарын үсэг зурж баталгаажуулсан эхний ирүүлсэн санхүүгийн тайлан, холбогдох материалыг үндэслэн санхүүгийн аудит хийсэн болно.

Аудит хийх явцад шаардагдах дараах материалуудыг ирүүлээгүй тул аудитад хамруулаагүй болно. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө, бараа материалын товчоо тайлан, дэлгэрэнгүй тайлан, журнал, тооллогын бүртгэл /хэвлэсэн хувь/
2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, товчоо тайлан, журнал, тооллогын бүртгэл /хэвлэсэн хувь/
3. Эргэлтийн хөрөнгийн тооллогын бүртгэл /хуулбар хувь/ зэрэг материалуудыг ирүүлээгүй болно.

**Бид 2021 оны жилийн эцсийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар нягтлан бодох нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн бодлогын баримт бичиг, дотоод хяналтын системийг сайжруулахтай холбогдуулан дараах зөвлөмжүүдийг өгч байна.**

***Бодит байдал:***

Тус төрийн бус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад дараах зөрчилүүд байна. Үүнд:

1. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар бусад авлага эхний үлдэгдэл 0.00 төгрөг санхүүгийн тайлангийн тодруулгаар 1,850.00 мянган төгрөг гэж тус тус зөрүүтэй илэрхийлсэн байна.
2. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар урьдчилж төлсөн зардал тайлант оны эхэн буюу эцэст 1,850.00 төгрөгийн үлдэгдэлтэй гэж тусгасан ба авлагыг тооцоо нийлж баталгаажуулан акт үйлдэж ирүүлээгүй байна.
3. Татварын болон нийгмийн даатгалын тайлан ирүүлээгүй нь татвар нийгмийн даатгалын өр авлагыг шалгаж үзэх боломжгүй байна.

ВИЗИОН АУДИТ

4. Санхүүгийн тайлангаар касс дах бэлэн мөнгө оны эхэн буюу эцэст 38.59 төгрөгийн бэлэн мөнгөтэй, бараа материал оны эцэст 9,489,607.43 төгрөгийн үндсэн хөрөнгө, 8,706,881.42 төгрөгийн бараа материалтай гэж тусгасан ба тооллого хийх тухай тушаалын дагуу биетээр тоолсон боловч батлагдсан маягтаар тооллогыг явуулж тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулсан бүртгэлгүй үндсэн ба эргэлтийн хөрөнгийн холбогдох нягтлан бодох бүртгэлийн болон анхан шатны баримт хөтөлдөггүй гэж үзэхээр байна.
5. Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангаар орлого мөнгөн орлогын тайланд 176,586,885.30 төгрөг, орлогын задаргаа тайлангаар 170,017,500.00 төгрөгөөр тусгасан буюу 6,569,385.30 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлжээ. Орлогын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй зөвхөн орлогын задаргаа гэсэн хүснэгт хөтөлж хэвшсэн зөрчил байна. Үүнд:

| д/д | Орлогын нэр | Мөнгөн гүйлгээний тайлан | Орлогын задаргаа |
|---|---|---|---|
| 1 | Гишүүдийн татвараас орсон | 108,700,000.00 | 108,700,000.00 |
| 2 | Төсөл хөтөлбөрөөс орсон | 32,245,000.00 | 32,307,500.00 |
| 3 | Хандиваар хүлээн авсан | 8,040,000.00 | 8,040,000.00 |
| 4 | Хүүний орлогоос орсон | 2,297,184.30 | - |
| 5 | Нэр данс зөрүүтэй буцаалтын | 4,254,701.00 | - |
| 6 | Бусад мөнгөн орлого | 21,050,000.00 | 20,970,000.00 |
| 7 | **Нийт дүн** | **176,586,885.30** | **170,017,500.00** |
| 8 | **зөрүү** | **6,569,385.30** | |

***Зөвлөмж:***

**Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчимын 5.1-д** "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4. "үнэн зөв байх"-гэж заасан заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар"-ын нэгдүгээр бүлэгийн нийтлэг зүйлд "Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ". Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан " Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ийн 6 дугаар зүйлийн тооцооны үлдэгдлийн баталгаа хэсэгт: "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтлөнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны

хавсралтад нэгтгэж гаргана." гэж заасан заалтыг хэрэгжүүлэн мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

Зөрчилийн тухай хуулийн 1.25-д ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. гэж заасан байдаг.

**Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн** 12.1-д Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна, 12.2. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; гэсэн заалтыг хэрэгжүүлэх,

**Мөн хуулийн 20 дугаар зүйлийн** 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтыг мөрдөж ажиллах,

**Бодит байдал**

Санхүүгийн баримтын харилцах дансны хуулга болон ерөнхий журналын ард бараа материалын худалдан авсан зарлагын зарим баримтанд хүлээн авсан хүн гарын үсэг зурагдаагүй баримтанд нягтлан бодогч гарын үсэг зурж хянаагүй, Кассын баримтанд мөнгө хүссэн өргөдөлд мөнгө олгохыг зөвшөөрсөн захирал болон нягтлан бодогчийн гарын үсэггүй баримтуудаар гүйлгээ хийж санхүүгийн баримтанд үдсэн зэрэг зөрчилүүд байна. Санхүүгийн баримт үдэлт дугаарлалтгүй, товъёог хийгдээгүй үдсэн байна.

***Зөвлөмж:***

**Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дугаар зүйлд "** Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан " Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ийн ерөнхий зүйлд "Анхан шатны баримт гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог хэлнэ. Анхан шатны

баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо мөрдөх баримт, маягтыг энэ зааварт нийцүүлнэ", Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

**Мөн "Зөрчилийн тухай хууль"-ийн 11.18 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих хэсэгт** 1.Аж ахуйн нэгж, байгууллага:

1.5.гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах үүргээ биелүүлээгүй;

1.13. нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын нийтлэг загвар, бүрдүүлэх аргачлал, удирдах байгууллагаар батлуулсан өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг мөрдөөгүй;

1.15.анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, эсхүл шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, /тэмдэг/ дарж баталгаажуулах, цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримтыг цахим гарын үсгээр баталгаажуулах үүргээ биелүүлээгүй;

1.16.анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэсэн, санхүүгийн тайланд тусгасан;

1.25.ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. гэж заасан тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Иймд Төрийн бус байгууллагуудын тухай хууль, дүрэм, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Маягт заавар батлах тухай" 386 дугаар тушаалаар Төрийн бус байгууллагад мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн жагсаалт", "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх загвар", "Санхүүгийн тайлангийн А маягт", "Санхүүгийн тайлангийн Б маягт"-ын загварыг баталсан бөгөөд цаашид байгууллагынхаа санхүү бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Цаашид нягтлан бодох бүртгэлийн бодлого, зохион байгуулалт, үйл ажиллагаа, менежмент, хууль тогтоомж, заавар, журмыг хэрэгжүүлэх талаар та бүхний хийж буй ажлыг улам сайжруулахын тулд бидний өгч буй энэхүү зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдэгт итгэж байна.

**Аудитор** **Ц.Болдбаатар**

**Аудиторын туслах** **Б.Дэлгэрмаа**

Танилцаж зөвшөөрсөн

ВИЗИОН АУДИТ

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

# БИЗКОН АУДИТ ХХК

АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, АУТСОРСИНГ, СУРГАЛТ

2022 он 03 сар 04 өдөр Дугаар СТА-10/22 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"МБББСБХолбоо" ГҮТББ-ийн удирдлагад

**Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан**

**Дүгнэлт**

Бид "2021 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодолгын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "МБББСБХолбоо" ГҮТББ-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний өгсөн удирдлагын зөвлөмж тайланд тусгагдсан асуудлуудын санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг нөлөөллийг эс тооцвол "МБББСБХолбоо" ГҮТББ-ийн 2021 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

*Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ( АОУС )-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм-ийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ийн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

*Аудитын гол асуудлууд*

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Монгол Улс, Улаанбаатар-210646, Чингэлтэй дүүрэг, Найман шарга, "Бизкон Аудит" ХХК-н байр, ш/х 46-845,
[УТАС/ФАКС: 976-70119107, 976-11-312773, 976-99119107, 976-96969607, 976-95959107]
[Э-шуудан: info@bizcon.mn. Вэб: www.bizcon.mn]

***Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага***

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

***Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага***

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС –ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандалгыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

ХҮНДЭТГЭСЭН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л. ОТГОНБАЯР

БИЗКОН АУДИТ ХХК
BIZCON AUDIT LLC
УЛААНБААТАР ХОТ

"МББСБХолбоо" ГҮТББ
АУДИТЛАГДСАН БАЛАНС
2021 оны 12 сарын 31

( Төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| ХӨРӨНГӨ | | |
| Эргэлтийн хөрөнгө: | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 7,930,927.96 | 927,389.40 |
| Дансны авлага | 3,600,000.00 | |
| Татвар, НДШ-ийн авлага | | |
| Бусад авлага | 51,782,521.47 | 56,620,327.01 |
| Бараа материал | 7,146,971.42 | 8,706,881.42 |
| Бусад эргэлтийн хөрөнгө хангамж | | |
| Урьдчилж төлсөн тооцоо | 1,850,000.00 | 1,850,000.00 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **72,310,420.85** | **68,104,597.83** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 9,949,313.99 | 9,489,607.43 |
| Биет бус хөрөнгө | | |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| Дуусаагүй барилга | | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **9,949,313.99** | **9,489,607.43** |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 82,259,734.84 | 77,594,205.26 |
| ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР | | |
| **Богино хугацаат өглөг** | | |
| Дансны өглөг | 2,872,190.72 | |
| Цалингийн өглөг | | |
| Татварын өглөг | 2,114,000.00 | 7,910,287.21 |
| НДШ-ийн өглөг | | 1,453,636.34 |
| Богино хугацаат зээл | | |
| Хүүгийн өглөг | 253,046.98 | |
| Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| Урьдчилж орсон орлого | 3,600,000.00 | |
| **Богино хугацаат өглөгийн дүн** | **8,839,237.70** | **9,363,923.55** |
| **Урт хугацаат өглөг** | | |
| Урт хугацаат зээл | | |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| **Урт хугацаат өглөгийн дүн** | - | - |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **8,839,237.70** | **9,363,923.55** |
| **Эзэмшигчийн өмч** | | |
| Хувийн өмч | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Эзний өмчийн бусад хэсэг | | |
| Хуримтлагдсан ашиг | 73,420,497.14 | 68,230,281.71 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **73,420,497.14** | **68,230,281.71** |
| НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР | 82,259,734.84 | 77,594,205.26 |

1 БИЗНЕС АУДИТ

# АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО

"МББСБХолбоо" ГҮТББ
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2021 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| Гишүүдийн татвар | 108,150,000.00 | 108,700,000.00 |
| Сургалтын төслийн орлого | 46,595,009.00 | 32,307,500.00 |
| Тайлан байршуулсан сайтны орлого | | 5,720,000.00 |
| Бэлэн хандив, тусламжийн орлого, засгийн газрын буцаалт | 9,365,282.42 | 8,040,000.00 |
| Нэр данс зөрүү орлого | 474,128.63 | |
| Итгэлцлийн хүүний орлого | 7,154,111.86 | 7,925,649.91 |
| Банкны хүүний орлого | 469,376.25 | |
| Арга хэмжээний орлого | | 15,250,000.00 |
| **Нийт ашиг** | 172,248,283.26 | 178,982,052.53 |
| Гишүүнчлэлийн төсөл хэрэгжүүлсний зардал | | 23,240,390.00 |
| Сургалт хөтөлбөр хэрэгжүүлсний зардал | 36,436,450.00 | 24,397,945.00 |
| Цалингийн зардал | 65,877,402.92 | 75,243,986.46 |
| НДШ-ийн зардал | 3,775,866.60 | 8,604,601.48 |
| Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | | 29,000.00 |
| Тэтгэмж ба урамшууллын зардал | | 2,750,000.00 |
| Бичиг хэргийн зардал | | 1,446,790.00 |
| Шуудан холбооны зардал | 5,283,559.95 | 2,665,569.24 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | 9,230,000.00 | 7,540,900.00 |
| сургалтын зардал | | 99,000.00 |
| Хангамж материалын зардал | | 50,000.00 |
| Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал | 357,370.10 | 181,406.51 |
| засварын зардал | | 288,500.00 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 3,527,399.42 | 3,609,606.57 |
| Түрээсийн зардал | 18,775,760.00 | 17,003,045.00 |
| Сонин сэтгүүл захиалгын зардал | | 71,200.00 |
| Цэвэрлэгээ ариутгал, шинжилгээний зардал | | 60,000.00 |
| Зээлийн хүүгийн зардал | 396,309.70 | 667,924.27 |
| Тээвэр, шатахууны зардал | 89,000.00 | 492,106.00 |
| Хүлээн авалтын зардал | 1,729,324.00 | 3,334,146.00 |
| зар сурталчилгаа пи ар сонин-тв сайт | 6,720,000.00 | 4,665,775.00 |
| Оффисын хангамжийн зардал | | 1,472,614.00 |
| Засгийн газрын буцалтгүшй тусламж | 9,365,282.42 | |
| томилолтын зардал | 6,023,736.70 | |
| Бусад зардал | 4,660,821.45 | 1,067,547.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз) | | |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз) | | |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз) | | |
| **Татварын өмнөх ашиг** | (40,375.10) | (1,038,902.62) |
| Татварын зардал | 1,860,515.99 | 790,660.07 |
| **Цэвэр ашиг** | (1,900,891.09) | (1,829,562.69) |

ВИЗИОН АУДИТ

"МББСБХолбоо" ГҮТББ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2021 оны 12 сарын 31

( Төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | - | - | | 70,059,844.38 | 70,059,844.38 |
| **залруулсан үлдэгдэл** | | | | | |
| Тайлангийн хугацааны ашиг (алдагдал) | | | | (1,829,562.69) | (1,829,562.69) |
| **залруулсан үлдэгдэл** | | | | | |
| 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | - | - | | 68,230,281.69 | 68,230,281.69 |

3 ВИЗИОН АУДИТ

"[illegible]ББСБХолбоо" ГҮТББ
Мөнгөн гүйлгээний тайлан
2021 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| 1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 270,015,160.25 | 176,586,885.30 |
| [illegible]шүүдийн татвараас орсон орлого | 111,200,000.00 | 108,700,000.00 |
| Төсөл хөтөлбөрөөс орсон орлого | 45,515,009.00 | 32,245,000.00 |
| [illegible]диваар хүлээн авсан мөнгө | 99,382,000.00 | 8,040,000.00 |
| [illegible]ний орлогоос орсон | 469,376.25 | 2,297,184.30 |
| Татаас Нэр данс зөрүү буцаалтын орлого | | 4,254,701.00 |
| [illegible]ад мөнгөн орлого | 13,448,775.00 | 21,050,000.00 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага | 336,953,703.67 | 183,590,423.86 |
| Ажилчдад олгосон мөнгө | 59,311,669.16 | 65,930,716.76 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 6,311,890.14 | 15,379,014.62 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө | 146,491,220.38 | 63,213,113.48 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 118,997,171.45 | 9,915,050.00 |
| [illegible]ргалт хөтөлбөрийн зардал | | 27,094,945.00 |
| Хүүний төлбөрт төлсөн мөнгө | | |
| Татварын байгууллагад төлсөн мөнгө | 5,841,752.54 | 2,057,584.00 |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | | |
| Бусад мөнгөн зарлага | | |
| [illegible]ндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (66,938,543.42) | (7,003,538.56) |
| 2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| [illegible]рөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого | - | - |
| Хүлээн авсан хүүгийн орлого | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | | |
| Бусдад олгосон зээл,мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| [illegible]рөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага | - | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | | |
| Бусад мөнгөн зарлага | | |
| [illegible]өрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| [illegible]нхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого | 15,000,000.00 | |
| Зээл авсан, орнийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө | 15,000,000.00 | |
| Бусад мөнгөн орлого | | |
| [illegible]нхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага | 40,000,000.00 | |
| Зээл төлсөн мөнгө | 40,000,000.00 | |
| Бусад мөнгөн зарлага | | |
| Валютийн ханшийн зөрүү | 3,717.48 | |
| [illegible]анхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (25,003,717.48) | |
| 4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (41,934,825.94) | (7,003,537.66) |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 49,865,753.00 | 7,930,927.06 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 7,930,927.06 | 927,389.40 |

Аудитор Б.Наранбат

Аудиторын туслах Б.Дэлгэрмаа

Хүлээн зөвшөөрсөн

ВИЗИОН АУДИТ

## 1. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | | |
|---|---|---|
| 1.1 | Байгууллагын нэр: | "МББСБХОЛБОО" ГҮТББ |
| 1.2 | Улсын бүртгэлийн дугаар: | 9071032018 |
| 1.3 | Регистрын дугаар: | 1024949 |
| 1.4 | Үүсгэн байгуулсан баримт бичиг: | Дүрэм |
| 1.5 | Үйл ажиллагааны чиглэл / код/: | 4610 Санхүүгийн холбогдолтой мэдээ мэдээллээр хангах, сургалт семинар зохион явуулах, тэдний үйл ажиллагааг сурталчлах, гишүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах |
| 1.6 | Дүрмийн сан: | 0 төгрөг |
| 1.7 | УЗ Дарга:<br>Гүйцэтгэх захирал<br>Ерөнхий нягтлан бодогч | З.Алтанзул<br>А.Мөнхбаяр<br>Б.Мөнхтуяа |
| 1.8 | Гэрчилгээн дээрх хаяг: | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Төмөрчний гудамж, ЕХЕ плаза 2 давхарт, |
| 1.9 | Үүсгэн байгуулагдсан огноо: | 2002 оны 12 сарын 06 |
| 1.10 | Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо: | 2012 оны 11 сарын 12 |

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН БАЙДАЛ

Тус компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр тайлангуудад хийсэн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

Компанийн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн байна.

*2.1 Үнэлгээний* суурь

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн аккруэл сууриар бэлтгэсэн.

*2.2. Таамаглал, тооцоолол ба үнэлгээний хэрэглээ*

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр,

орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Бодит үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ, тооцоолол түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөлөл нь байнга хянаж шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

Санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнгүүдэд материаллаг нөлөө үзүүлэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын тодорхой бус асуудлуудыг доор дурьдсан орлогын тодруулгын хэсэгт багтаасан болно

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ өөрийн компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримталдаг бөгөөд бодлогын баримт бичгийг цаашид сайжруулах шаардлага байгаа болно.

### 3.1. Мөнгө хөрөнгийн бүртгэлийн бодлого

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга
СТОУС-7 Санхүүгийнн хэрэглүүр: Тодруулга
НББОУС-32 Санхүгийн хэрэглүүр: Толилуулга

Компанийн касс дахь болон банкны харилцах дансанд байгаа төгрөг, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлсийг мөнгөн хөрөнгөнд хамааруулна. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэнэ.

### 3.2. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга
НББОУС-16 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн зүйлийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг.

- Хөрөнгөд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай
- Хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой

Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг дараах зүйлсээс бүрдэнэ.

- Гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татварын дүнг оруулсан худалдааны хөнгөлөлт, буцаалтыг хассаны дараах худалдан авалтын үнэ
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгох түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой аливаа шууд зардлууд
- Тухайн зүйлийг олж эзэмших үед эсвэл түүнийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлын анхны тооцоолол.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөний дараа үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл ба

6 ВИЗИОН АУДИТ

хүримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр үнэлдэг. Бөөн дүнгээр худалдан авсан хөрөнгийн үнийг худалдан авсан хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэд үндэслэн хуваарилдаг. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгэнэ. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж үндсэн хөрөнгийг барьж дуустал гарсан зээлийн хүүг капиталжуулах бөгөөд түүнээс хойшхи гарсан хүүгийн зардлыг капиталжуулахгүй.

*Элэгдэл*

Үндсэн хөрөнгийн элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилсан хуваарилалт юм. Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг түүний бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн дагуу тооцно.

### 3.3. Орлогын бүртгэлийн бодлого

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
СТОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө
НББОУС 18 Орлого

Орлого гэдэг нь байгууллагын ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд өөрийн капитал болгон өмч эзэмшигчдээс оруулсан хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт, өрийн бууралт хэлбэрээр илэрсэн хөрөнгийг бий болгох буюу нэмэгдүүлж буй эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм.

*Орлого хүлээн зөвшөөрөх*
Эдийн засгийн ирээдүйн үр ашгийн хэмжигдэж болохуйц өсөлт нь хөрөнгийг нэмэгдүүлэх буюу өр төлбөрийг багасгаж байвал орлого, үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрдөг. Орлогыг хүлээн зөвшөөрснөөр хөрөнгийн өсөлт болон өр төлбөрийн бууралтыг нэг зэрэг хүлээн зөвшөөрнө.

### 3.4. Зардлын бүртгэлийн бодлого

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
НББОУС 23 Зээлийн өртөг
НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө

Зардал гэдэг нь хөрөнгийг хасагдуулж, элэгдүүлэх хэлбэрээр тайлант үед гарсан эдийн засгийн үр ашгийн бууралт буюу өмч эзэмшигчдэд хуваарилахаас бусад байдлаар өмчийг багасгах, өр төлбөр нэмэгдэхийг хэлнэ. Зардлын тодорхойлолтонд байгууллагын үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны явцад үүссэн зардлыг хамааруулна.

*Зардлыг хүлээн зөвшөөрөх*
Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг баримтлан жинхэнэ хэрэгжилтийн зарчмын дагуу бүртгэлээ хөтлөх тул тэдгээрийг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран

ВИЗИОН АУДИТ

үйл явдал, ажил гүйлгээ хийгдсэн тухайн тайлангийн хугацааанд нь хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана.

Хөрөнгө багасгах буюу өр төлбөр нэмэгдсэний улмаас эдийн засгийн үр өгөөж буурч, улмаар энэ бууралтыг найдвартай хэмжих боломжтой байвал түүнийг орлого, үр дүнгийн тайланд зардал гэж хүлээн зөвшөөрнө. Энэ зардлыг хүлээн зөвшөөрөхдөө өр төлбөрийн өсөлт буюу хөрөнгийн бууралтыг хамтад нь хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Мөн гарсан зардал болон тодорхой зүйлийн өртгийг түүнтэй холбоотой олсон орлогод шууд хамааруулах үндсэн дээр хүлээн зөвшөөрнө. Орлого, зардал зохицох зарчим нь ажил гүйлгээ болон бусад үйл явдлын үр дүнд бий болсон орлого ба зардлыг нэгэн зэрэг хамтад нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

*Үйл ажиллагааны зардал*

Байгууллагын ажилтнуудын цалин, нийгмийн даатгал, материал, хангамж, цахилгаан, халаалт, дулаан, цэвэр ба бохир ус, харилцаа холбоо, шатахуун, бичиг хэрэг, томилолт, элэгдлийн зардлууд зэрэг хамаарна.

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

"Нийгмийн даатгалын тухай" хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд үг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

## 1. мөнгөн хөрөнгө

2021 оны 12 сарын 31-ны байдлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

**1.1 Бэлэн мөнгө**

| **Дансны нэр** | 2021.12.31 |
|---|---|
| Касс төгрөг | 38,587.00 |
| Нийт дүн | 38,587.00 |

**1.2 Харилцах дансан дахь мөнгө**

| **Дансны нэр** | 2021.12.31 |
|---|---|
| Харилцах-ам доллар | 34,186.56 |
| Харилцах-41 | 526,911.97 |
| Харилцах төгрөг | 327,703.87 |
| **Нийт мөнгөн хөрөнгийн дүн** | 888,802.40 |

8 ВИЗКОН АУДИТ

## 2. АВЛАГА

2021 оны 12 сарын 31-ны байдлаар авлага дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Итгэлцлийн авлага | 50,617,165.96 |
| Итгэлцлийн хүүгийн авлага | 6,003,161.05 |
| Бусад авлага | - |
| **Дүн** | **56,620,327.01** |

## 3. Хангамж материал

2021 оны 12 сарын 31-ны байдлаар бараа материал дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Бэлэн бүтээгдэхүүн | 8,706,881.42 |
| **Дүн** | **8,706,881.42** |

## 4. Урьдчилж төлсөн тооцоо

2021 оны 12 сарын 31-ны байдлаар бараа материал дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Урьдчилж төлсөн тооцоо | 1,850,000.00 |
| **Дүн** | **1,850,000.00** |

## 5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Компанийн үндсэн хөрөнгө 2021 оны 12 сарын 31-р доорх байдалтай байна.

| Үндсэн Хөрөнгө | |
|---|---|
| Дансны нэр | 2021.12.31 |
| Тээврийн хэрэгсэл | 11,421,579.00 |
| Хүр.элэгдэл | (3,506,621.59) |
| Тавилга эд хогшил | 10,973,700.00 |
| Хүр. элэгдэл | (9,398,749.99) |
| **Дүн** | **9,489,607.43** |

## 6. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Татварын өглөг | 7,910,287.21 |
| НДШ-ын өглөг | 1,453,636.34 |
| **Дүн** | **9,363,923.55** |

визион аудит

## 7. ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Хуримтлагдсан үр дүн | 68,230,281.70 |
| **Дүн** | **68,230,281.70** |

## 8. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Тайлант жилийн үндсэн үйл ажиллагааны орлого дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Гишүүдийн татварын орлого | 108,700,000.00 |
| Сургалт, төслийн орлого | 32,307,500.00 |
| Тайлан байршуулсан сайтны орлого | 5,720,000.00 |
| Бэлэг, хандив, тусламжийн орлого | 8,040,000.00 |
| Итгэлцлийн хүүний орлого | 7,925,649.91 |
| Арга хэмжээний орлого | 15,250,000.00 |
| **Нийт ашиг** | **177,943,149.91** |

## 9. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Тайлант хугацааны Ерөнхий ба Удирдлагын зардал дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

| Дансны нэр | 2021.12.31 |
|---|---|
| Цалингийн зардал | 75,243,986.45 |
| НДШ-ийн зардал | 8,604,601.48 |
| Албан татвар хураамж | 29,000.00 |
| Тэтгэмж ба урамшууллын зардал | 2,750,000.00 |
| Бичиг хэргийн зардал | 1,446,790.00 |
| Шуудан холбооны зардал | 2,665,569.24 |
| Бусдаар гүйцэтгүлсэн ажил | 7,540,900.00 |
| Сургалтын зардал | 99,000.00 |
| Хангамж материалын зардал | 50,000.00 |
| Банкны шимтгэлийн зардал | 181,406.51 |
| Засварын зардал | 288,500.00 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 3,609,606.37 |
| Түрээсийн зардал | 17,003,045.00 |
| Сонин сэтгүүл захиалгын зардал | 71,200.00 |
| Цэвэрлэгээ ариутгал, шинжилгээний зардал | 60,000.00 |
| Зээлийн хүүгийн зардал | 667,924,27 |
| Тээвэр, шатахууны зардал | 390,106.00 |
| Хүлээн авалтын зардал | 3,334,146.00 |

10 ВИЗИОН АУДИТ

| | |
|---|---|
| Зар суртчилгааны зардал | 4,665,775.00 |
| Бусад зардал | 1,067,547.00 |
| Хангамж оффисын зардал | 1,472,614.00 |
| Гишүүнчлэлийн төсөл | 23,342,390.00 |
| хэрэгжүүлсний зардал | 24,397,945.00 |
| Сургалтын зардал | |
| **Ерөнхий ба Удирдлагын зардал** | **178,982,052.52** |

## 10. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

2021 оны 12-р сарын 31-наар бидэнд мэдэгдэж байгаа томоохон зарга, маргаан, нэхэмжлэл үгүй байна. Өөрөөр хэлбэл байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрөхүйц болзошгүй өр төлбөр байхгүй байна.

Гүйцэтгэсэн,

Аудитор Ц.Болдбаатар

Туслах аудитор Б.Дэлгэрмаа

Хүлээн зөвшөөрсөн:

03 11 2022

ВИЗИОН АУДИТ




Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Сүхбаатарын талбайн гудамж 20-2
Ub Grand зочид буудлын 10 давхарт 1001 тоот
967-7700 8380
Цахим шуудан: info@bbsb.mn
www.bbsb.mn